

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дарви сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/175/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2026 он</p>	<p>Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn</p> <p>Цахим актив аудит ХХК -ын Аудитор: Д.Балжинням Утас:70432545 Цахим хаяг: Damiranbaljinnyam573@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	12
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	14
5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл.....	15

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

2026.02.25 № 182
танай _____-ны № _____-т

ДАРВИ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ЭРХЛЭГЧ ЭМЧ Б.ЭНХЖИН
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дарви сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Онцлох асуудал нь тайлант оны эм, эмнэлгийн хэрэгслийн үлдэгдэл 46.6 сая төгрөг, үүний 7.6 сая төгрөг нь он дамжсан үлдэгдэл байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд урсгал төсвөөс 21.9 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, харьяа дээд шатны байгууллага болон ОНХС, хандив тусламжаар 98.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хүлээн авсан байна.

8426050431

Дарви сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Бусад асуудал

Үйл ажиллагааны эрхэм зорилгын хүрээнд 2025 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 хөтөлбөр, 4 зорилтын хүрээнд 61 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Төлөвлөгөөний гүйцэтгэлийг эрх бүхий албан тушаалтнаар дүгнүүлэн биелэлтийг 93.0 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>380,182,369.46</u>	<u>430,826,291.58</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	215,614,111.07
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	215,614,111.07
3121	Төгрөг	-	215,614,111.07
31211	Төрийн сангийн харилцах	-	215,614,111.07
33	АВЛАГА	243,902,384.81	110,227,005.81
33300	Татаас, санхүүжилтийн авлага	243,902,384.81	109,772,705.81
335	Бусад авлага	-	454,300.00
3351	Байгууллагаас авах авлага	-	454,300.00
34	УРЬДЧИЛГАА	330,000.00	330,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	330,000.00	330,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	135,949,984.65	104,655,174.70
351	Түүхий эд материал	96,255,614.65	66,691,294.70
35110	Тусгай зориулалттай материал	20,101,011.18	20,101,011.18
35130	Эм боох материал	76,154,603.47	46,590,283.52
354	Хангамжийн материал	39,694,370.00	37,963,880.00
35460	Хүнсний материал	3,424,940.00	1,694,450.00
35470	Бусад хангамжийн материал	36,269,430.00	36,269,430.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,245,857,223.12</u>	<u>1,175,249,162.83</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,245,857,223.12	1,175,249,162.83
392	Биет хөрөнгө	1,221,857,222.92	1,151,249,162.83
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,025,734,792.00	1,035,734,792.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(199,805,843.48)	(245,573,426.96)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	221,142,321.00	221,142,321.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(100,575,351.48)	(143,314,927.12)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	357,629,665.17	446,787,765.17
39206	Хуримтлагдсан элэгдэл	(139,632,781.01)	(217,322,214.99)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	91,301,500.00	101,981,500.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(34,188,579.28)	(48,438,146.27)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	201,500.00	201,500.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,831,410.00	1,831,410.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,831,410.00)	(1,831,410.00)
39217	Ном	50,000.00	50,000.00
393	Биет бус хөрөнгө	24,000,000.20	24,000,000.00
39301	Програм хангамж	1,800,000.00	1,800,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,799,999.80)	(1,800,000.00)

Дарви сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

39303	Бусад биет бус хөрөнгө	24,000,000.00	24,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,626,039,592.58</u>	<u>1,606,075,454.41</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>7,041,037.84</u>	<u>768,349.98</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	7,041,037.84	768,349.98
413	Өглөг	7,041,037.84	768,349.98
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	5,225,762.12	768,349.98
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,618,998,554.74</u>	<u>1,605,307,104.43</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,618,998,554.74	1,605,307,104.43
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	350,903,057.00	350,903,057.00
51101	Өмч: - төрийн	350,903,057.00	350,903,057.00
512	Хуримтлагдсан үр дүн	633,748,948.81	620,057,498.50
51210	Өмнөх үеийн үр дүн	633,748,948.81	633,841,964.53
51220	Тайлант үеийн үр дүн	-	(13,784,466.03)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	634,346,548.93	634,346,548.93
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,626,039,592.58</u>	<u>1,606,075,454.41</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,481,692,225.97	1,662,791,169.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	206,295,781.90	144,995,564.30
120	Нийтлэг татварын бус орлого	194,295,781.90	144,995,564.30
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	194,295,781.90	144,995,564.30
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,000,000.00	27,474,988.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	185,295,781.90	117,520,576.30
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,275,396,444.07	1,517,795,605.50
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	89,459,100.00	92,631,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	89,459,100.00	92,631,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,185,937,344.07	1,425,163,905.50
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,185,937,344.07	1,425,163,905.50
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,341,734,171.44	1,676,575,635.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,341,734,171.44	1,676,575,635.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,341,734,171.44	1,642,046,187.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	718,555,362.72	891,087,278.05
210101	Үндсэн цалин	420,616,143.72	468,431,054.82

Дарви сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210102	Нэмэгдэл	213,371,869.00	296,571,933.23
210103	Унаа хоолны хөнгөлөлт	28,249,000.00	54,340,000.00
210104	Урамшуулал	56,318,350.00	71,744,290.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,757,998.40	103,391,696.78
210201	Тэтгэврийн даатгал	58,436,110.02	70,686,451.20
210202	Тэтгэмжийн даатгал	7,326,453.42	9,075,294.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,607,126.73	4,702,383.06
210204	Ажилгүйдлийн даатгал	3,077,661.67	3,785,513.95
210205	Эрүүл мэндийн даатгал	12,310,646.56	15,142,054.01
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	82,092,915.72	81,874,251.94
210301	Гэрэл, цахилгаан	7,035,075.72	6,286,411.94
210302	Түлш, халаалт	75,057,840.00	75,057,840.00
210303	Цэвэр, бохир ус	-	530,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	59,471,136.00	64,342,260.00
210401	Бичиг хэрэг	11,044,660.00	9,776,050.00
210402	Тээвэр, шатахуун	33,924,976.00	47,913,681.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,030,000.00	4,535,029.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	2,117,500.00
2105	Нормативт зардал	149,182,743.97	217,281,463.71
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	122,944,378.97	178,238,074.65
210502	Хоол, хүнс	26,238,365.00	34,723,389.06
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	4,320,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,947,800.00	20,101,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,064,100.00	10,355,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	9,746,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,384,000.00	5,346,000.00
210702	Дотоод албан томилолт	3,384,000.00	5,346,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,783,450.00	7,159,087.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,833,450.00	6,209,087.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	650,000.00	650,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	300,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	220,558,764.63	251,462,650.29
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,276,950.00	60,897,490.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	188,281,814.63	190,565,160.29
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	34,529,448.06
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	24,798,000.00

Дарви сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	24,648,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	150,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	9,731,448.06
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	9,731,448.06
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	139,958,054.53	(13,784,466.03)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	139,958,054.53	(13,784,466.03)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,031,494,059.26	1,679,400,272.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	27,474,988.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	27,474,988.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	27,474,988.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	27,474,988.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,031,494,059.26	1,651,925,284.50
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	89,459,100.00	92,631,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	89,459,100.00	92,631,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	942,034,959.26	1,559,293,584.50
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	942,034,959.26	1,559,293,584.50
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,172,556,222.05	1,441,888,161.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,172,556,222.05	1,441,888,161.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,172,556,222.05	1,407,358,713.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	719,301,329.00	872,979,264.38
210101	Үндсэн цалин	392,935,718.00	445,136,793.15
210102	Нэмэгдэл	238,170,050.00	296,181,503.23
210103	Унаа хоолны хөнгөлөлт	28,239,000.00	59,916,618.00
210104	Урамшуулал	59,956,561.00	71,744,350.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,870,743.47	121,499,710.45
210201	Тэтгэврийн даатгал	62,062,363.47	79,173,645.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,022,076.00	14,575,927.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,992,189.00	4,232,362.72
210204	Ажилгүйдлийн даатгал	2,758,821.00	3,418,799.00

Дарви сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	11,035,294.00	20,098,976.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83,701,000.00	82,900,251.94
210301	Гэрэл, цахилгаан	7,500,000.00	7,312,411.94
210302	Түлш, халаалт	75,077,300.00	75,057,840.00
210303	Цэвэр, бохир ус	1,123,700.00	530,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	51,259,076.00	72,505,560.00
210401	Бичиг хэрэг	6,804,100.00	8,963,550.00
210402	Тээвэр, шатахуун	28,924,976.00	48,792,981.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,030,000.00	4,535,029.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,372,000.00	5,969,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,128,000.00	4,245,000.00
2105	Нормативт зардал	155,871,823.58	191,199,339.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	135,692,649.52	144,979,629.60
210502	Хоол, хүнс	19,748,174.06	35,454,710.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	431,000.00	10,765,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,245,000.00	11,959,750.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	24,108,500.00	10,118,750.00
210604	Урсгал засвар	5,758,100.00	1,841,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,384,000.00	5,346,000.00
210702	Дотоод албан томилолт	3,384,000.00	5,346,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,790,450.00	7,159,087.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,840,450.00	6,184,087.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	650,000.00	650,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	300,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	25,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,132,800.00	41,809,750.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,132,800.00	41,809,750.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	34,529,448.06
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	24,798,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	24,648,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	150,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	9,731,448.06
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	9,731,448.06
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(141,062,162.79)	237,512,111.07
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	21,898,000.00

Дарви сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	21,898,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	21,898,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		21,898,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	(21,898,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(141,062,162.79)	215,614,111.07
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	215,614,111.07

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	350,903,057.00	634,346,548.93	633,748,948.81	1,618,998,554.74
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	93,015.72	93,015.72
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	350,903,057.00	634,346,548.93	633,841,964.53	1,619,091,570.46
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(10,047,689.95)	(10,047,689.95)
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	350,903,057.00	634,346,548.93	623,794,274.58	1,609,043,880.51
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	350,903,057.00	634,346,548.93	623,794,274.58	1,609,043,880.51
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	93,015.72	93,015.72
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	350,903,057.00	634,346,548.93	623,887,290.30	1,609,136,896.23
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(13,784,466.03)	(13,784,466.03)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	350,903,057.00	634,346,548.93	610,102,824.27	1,595,352,430.20

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

	Үзүүлэлт	Тайлант оны
--	----------	-------------

Дарви сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Эдийн засгийн ангилал		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,832,125,851.94	1,454,054,713.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,832,125,851.94	1,454,054,713.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,805,977,851.94	1,429,256,713.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,101,395,400.00	872,979,264.38
210101	Үндсэн цалин	542,733,300.00	445,136,793.15
210102	Нэмэгдэл	481,386,500.00	296,181,503.23
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,275,600.00	59,916,618.00
210104	Урамшуулал	70,000,000.00	71,744,350.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	137,979,100.00	121,499,710.45
210201	Тэтгэврийн даатгал	93,005,500.00	79,173,645.00
210202	Тэтгэмжийн даатгал	11,243,400.00	14,575,927.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,621,700.00	4,232,362.72
210204	Ажилгүйдлийн даатгал	5,621,700.00	3,418,799.00
210205	Эрүүл мэндийн даатгал	22,486,800.00	20,098,976.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	82,900,251.94	82,900,251.94
210301	Гэрэл, цахилгаан	7,312,411.94	7,312,411.94
210302	Түлш, халаалт	75,057,840.00	75,057,840.00
210303	Цэвэр, бохир ус	530,000.00	530,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	99,124,700.00	72,505,560.00
210401	Бичиг хэрэг	10,670,900.00	8,963,550.00
210402	Тээвэр, шатахуун	68,240,000.00	48,792,981.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,031,400.00	4,535,029.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,582,400.00	5,969,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,600,000.00	4,245,000.00
2105	Нормативт зардал	232,597,500.00	191,199,339.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	179,712,500.00	144,979,629.60
210502	Хоол, хүнс	38,760,000.00	35,454,710.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	14,125,000.00	10,765,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	63,500,000.00	33,857,750.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	45,000,000.00	32,016,750.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,500,000.00	-
210604	Урсгал засвар	15,000,000.00	1,841,000.00
2107	Томилолт, зочны зардал	8,000,000.00	5,346,000.00
210702	Дотоод албан томилолт	8,000,000.00	5,346,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,788,600.00	7,159,087.00

Дарви сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,050,000.00	6,184,087.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	650,000.00	650,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25,000.00	25,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	258,600.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	500,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,925,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	61,692,300.00	41,809,750.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	61,692,300.00	41,809,750.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,148,000.00	24,798,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,148,000.00	24,798,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	24,648,000.00	24,648,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	150,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,832,125,851.94	1,669,668,824.44
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	82,900,251.94	82,900,251.94
132001	Орон нутгийн төсвөөс	82,900,251.94	82,900,251.94
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,721,815,200.00	1,559,293,584.50
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,721,815,200.00	1,559,293,584.50
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	27,410,400.00	27,474,988.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	27,410,400.00	27,474,988.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		215,614,111.07

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 257,164.7 мянган төгрөгийн алдаа¹ зөрчил илэрч, санхүүгийн тайланд 249,493.3 мянган төгрөгийн алдааг залруулга хийлгэлээ. Үүнд:

- Санхүүгийн программд үндсэн хөрөнгө бүртгэхдээ ашиглах жил оруулаагүйтэй холбоотой 9 нэр төрлийн хөрөнгөд элэгдэл тооцоогүй 3,736.8 мянган төгрөг
- Өмнөх оны санхүүжилтийн авлагыг мөнгөн орлогоор хүлээн зөвшөөрч бүртгээгүй 243,902.4 мянган төгрөг
- Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хувиарласан мөнгөн хөрөнгийг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгээгүй 1,854.1 мянган төгрөг

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

- Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын бичилт буруу бүртгэсэнтэй, тайлант оны үр дүн зөрүүтэй илэрхийлсэн 378.0 мянган төгрөг

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Аудитаар залруулагдаагүй 7,671.4 мянган төгрөгийн 2 алдаа зөрчил² илэрсэнд зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 2 зөвлөмж хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй материаллаг алдааны зөрчил нь тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 19,678.6 мянган төгрөгөөс бага байгаа тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.1.1 Эдийн засгийн ангилалт, төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд эм боох материалын зардалд батлагдсан 4,200.0 мянган төгрөгийг гүйцэтгэлээр урамшууллын зардалд зарцуулж, эдийн засгийн ангилал зөрчин гүйлгэн зарцуулалт хийсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 112 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал”, хоёрдугаар хавсралт “Зардлын эдийн засгийн ангилалын тайлбар”-ын Хэрэглүүрийн гуравт: “Төсөв боловсруулж батлуулах, гүйцэтгэлийн тайлан гаргах, зардлын хяналт, аудит хийхэд ашиглана”, Төсвийн захирагчийн үүрэгт: “Зардлын ангилалын тодорхойлолтод заасны дагуу нийцүүлж зөв бүртгэх, мэдээлэх, тайлагнах үүргийг төсвийн бүх шатны захирагчид хүлээнэ” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зардлын зүйл ангийг эдийн засгийн ангиллын дагуу зөв бүртгэж, зарцуулалтыг үнэн зөв гаргах

3.1.2 Худалдан авалт, эмийн тендер оролцогчтой холбоотой гэрээний хэрэгжилт

Илрүүлэлт: Ерөнхий гэрээний худалдан авалтаар нийлүүлэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийг төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан аваагүйтэй холбоотой 3,471.4 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31.2-т “Энэ хуулийн 37.2.4-т тодорхойлсон захиалагч ерөнхий

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дарви сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.4-д "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно", Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын 2025 оны 01/103 албан тоотын заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ерөнхий гэрээнд заасан эм, эмнэлгийн хэрэгслийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан авалт хийх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дүгээр сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 05 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл /мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн программд үндсэн хөрөнгө бүртгэхдээ ашиглах жил оруулаагүйтэй холбоотой 9 нэр төрлийн 25.4 сая төгрөгийн хөрөнгөд элэгдэл тооцоогүй,	1	3,736.8	1	3,736.8			1	3,736.8
Өмнөх оны санхүүжилтийн авлагыг мөнгөн орлогоор хүлээн зөвшөөрч бүртгээгүй	1	243,902.4			1	243,902.4	1	243,902.4
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хувиарласан хөрөнгийг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгээгүй	1	1,854.1			1	1,854.1	1	1,854.1
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын бичилт буруу бүртгэсэнтэй, тайлант оны үр дүн зөрүүтэй илэрхийлсэн	1	378,0			1	378,0	1	378,0
Нийт дүн	4	249,493.3	1	3,736.8	3	246,134.5	4.0	249,493.3

Дарви сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд эм боох материалын зардалд батлагдсан 4,200.0 мянган төгрөгийг гүйцэтгэлээр урамшууллын зардалд зарцуулж, эдийн засгийн ангилал зөрчин гүйлгэн зарцуулалт хийсэн байна.	1	4,200.0					1	4,200.0
Ерөнхий гэрээний худалдан авалтаар нийлүүлэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийг төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан аваагүй	1	3,471.4					1	3,471.4
Дүн	2	7,671.4	0	0	0	0	2	7,671.4

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			